



## “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М. ГАНБААТАР

	Оосорлогч- дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-06	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он 09 сар 06 өдөр
		Тушаал № А/92	

## ООСОРЛОГЧ-ДОХИОЧНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Оосорлогч- дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-06	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он ....сар .... өдөр
		Тушаал №	

# ООСОРЛОГЧ-ДОХИОЧНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-06
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-06
	Хувилбар: 1

## Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага .....	4
Хоёр. Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлага .....	4
Гурав. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа .....	4

Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-06
	Хувилбар: 1

### **НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

- 1.1. Оосорлогч-дохиочны сургалтанд хамрагдсан, мэргэжлийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх.
- 1.2. Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах (гэрэл ойлгогч хантааз заавал байх) хэрэгслээр бүрэн хангагдсан байх.

### **ХОЁР. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙ ШААРДЛАГА**

- 2.1. Ажил гүйцэтгэж буй нэгж, хэсгийн ахлахын шийдвэрээр оосорлогч-дохиочиноор ажиллах ажилтан нь тухайн хэсгийн ахлах ажилтнаас зааварчилгаа авна.
- 2.2. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг /каска, малгай, бээлий, хантааз г.м/ бүрэн хэрэглэнэ.
- 2.3. Өргөн тээвэрлэх механизмын оператортой дохиог хэрхэн өгөх, хэрхэн ойлгох талаар урьдчилан ярилцаж тохиролцсон байна.
- 2.4. Ажил эхлэхийн өмнө оосорлогч-дохиочин нь:
  - Ачаа оосорлох хэрэгслийг /ган татлага, дэгээ тэнжээ/ нэг бүрчлэн шалгаж аюулгүй ажиллагааны шаардлага хангаж буй эсэхийг шалгана.
  - Ажил эхлэх цагийг кранчинтай тохирно.

### **ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

- 3.1. Ачааг өргөж, шилжүүлэх үед унахгүйгээр найдвартай баглаж оосорлосон байхын зэрэгцээ ачааг жигд тэнцүүлэн баглаж оосорлоно.
- 3.2. Ган татлага гинж нь зангилаа, илүү гогцоо мушгиагүй байвал зохино.
- 3.3. Хоёр салаа дэгээнд ачааг тэнцүүлэх байдлаар оосорлон өргөх механизмын дэгээг өргөх ачааныхаа эгц дээр байрлуулбал зохино.
- 3.4. Сул задгай буюу унахаар ачаа байвал тэдгээрийг засаж аюулгүй ажиллагааг хангахуйц нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.5. Өөрийн биеийн жингээр тэнцүүлж болохгүй. Ачааны доор хүн байгаа үед ачааг өргөн, шилжүүлж зөөвөрлөхийг хориглоно.
- 3.6. Оосорлогч нь өөрөө явагч сумт өргөгчийн даацанд тохирсон жинтэй ачааг өргүүлэхийн өмнө краны бүх бэхэлгээ тулгуурыг кранчнаас шаардах үүрэгтэй.
- 3.7. Тусгай сав, чингэлэг, боодол баглаатай ачааг ачиж буулгах, тээвэрлэх үед нурж унахааргүй байх нөхцөлийг бүрдүүлсний дараа уг ажлыг гүйцэтгэнэ.
- 3.8. Барааг өрж хураахдаа, хураалттай барааны хооронд технологийн заавар ёсоор явах зай үлдээсэн байвал зохино.

Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-06
	Хувилбар: 1

- 3.9. Ачааг өргөж, буулгахын өмнө хураалттай материалын ойролцоо хүн байгаа эсэхийг шалгахын хамт оосорлогч өөрөө энэ бүсээс гарсан байвал зохино.
- Оосорлосон ачаа, газартай наалдсан, бэхлэгдсэн зүйл байгаа эсэх
  - Ажлын байрны аюулгүй ажиллагаа хангагдсан эсэх
  - Өргөгчийн дэргэд болон үйлчлэх бүсэд хүн байгаа эсэх
  - Оосорлогч өөрөө аюулгүй замд гарч өргөгчийн кранчинд сайн харагдах газраас дохио өгөх боломжтой эсэх
- 3.10. Ачааг 20 см өргүүлж, ачаа бат найдвартай баглагдсан оосорлогдсон, оосорлох хэрэгсэл жигд чангарсан, ачаа унаж задрах эсэхийг шалгаж үзнэ. Ачааны оосорлогоог засах шаардлага гарвал тэр дор нь буулгах дохио өгнө.
- 3.11. Дохиог кранчинд сайн харагдах газраас өгөх бөгөөд харин тэгэхдээ өргөж байгаа буюу буулгаж байгаа ачааны ойролцоо зогсохгүйгээр аюулгүй бүсэд заавал байвал зохино.
- 3.12. Орчин муу харагдаж байгаа үед оосорлогчоор өөр хүнээр дохио өгүүлэх. Ачааг өргөхөд оосорлох хэрэгслийг гулгаж мултарч байвал засах гэж оролдох, хэрэв ийм байдал ажиглагдвал тэр дор нь буулгах дохио өгч буулгасны дараа оосорлогоог засах хэрэгтэй.
- 3.13. Ажил гүйцэтгэж байх үед гар, утас, чихэвчний хөгжим зэрэг нэмэлт тоноглол ашиглахыг хориглоно.
- 3.14. Ажил завсарлах үед ачааг өргөсөн чигээр нь орхиж болохгүй, ачааг заавал буулгасан байх ёстой.